

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ*Дугаар:***ХУРЛЫН ТОВ**

Хурал болсон газар	Хан-Уул дүүрэг, Соёлын ордны хурлын танхим
Он сар өдөр	2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр хуралдав.
Хурлын цаг	10:00-12:30 цагт боллоо.

ХУРЛЫН ИРЦ

Хурлын дарга	ТУЗ-ийн дарга Д.Даянбилгүүн
Хурлын ирц	58.50%
Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчид	120 хувьцаа эзэмшигчид

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. 2018 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах;
3. Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
4. Компанийн нэрийг өөрчлөх
5. Хөрөнгө оруулалт санхүүжилтын төлөвлөгөө
6. Дүрмийн өөрчлөлтийг батлах
7. ТУЗ-өөс гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах
8. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д. Шүрэнцэцэг хурлын дэгийг танилцуулав.
Хурлын ирцийг тооллогын комиссын дарга С.Батцэрэн мэдээлснээр хурал эхлэв.

Хурлын дэгийн дагуу компанийн 2018 оны үйл ажиллагаа болон 2019 оны ажлын төлөвлөгөө болон хөндлөнгийн аудитын дүгнэлтийг тус компанийн Гүйцэтгэх захирал Ц.Энхсайхан танилцуулав. Үүнд тус компани 2018 онд 202 сая төгрөгийн ашигтай ажилласан ба энэ нь 2017 оны үзүүлэлтээс 20.9 % өссөн үзүүлэлт юм.

Санхүү байдлын тайлангийн гол үзүүлэлтүүд /2017 онтой харьцуулав/

Үзүүлэлт	2017 он	2018 он
Эргэлтийн хөрөнгийн дүн	859,038,400	811,085,788
Үндсэн хөрөнгө	7,276,118,527	8,889,278,098
нийт хөрөнгийн дүн	10,509,492,984	10,268,454,513
Өр төлбөрийн нийт дүн	2,119,692,783	1,676,418,872
Эздийн өмчийн дүн	8,389,800,201	8,592,035,641

Борлуулалтын орлогын үзүүлэлт /2016 онтой харьцуулав/

Үзүүлэлт	2017 он	2018 он
Борлуулалтын орлого (цэвэр)	3,462,937,193	4,817,876,205
Борлуулалтын өртөг	3,011,613,847	4,147,961,114
Нийт ашиг (алдагдал)	451,323,346	669,915,091
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	167,616,596	202,235,440

Ажлын хамт олны хүчин чармайлтын үр дүнд борлуулалтын орлогын өсөлт 28-иар өссөн.

Үүний дараагаар хурлын дарга дбусад хэлэлцэх асуудлуудыг хувьцаа эзэмшигчид танилцуулав:

1. Компанийн нэрийг өөрчлөх
2. Хөрөнгө оруулалт санхүүжилтын төлөвлөгөө
3. Дүрмийн өөрчлөлтийг батлах
4. ТУЗ-өөс гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах
5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Үүний дараагаар дэгийн дагуу санал асуулгын ажиллагаа явагдав.

Хувьцаа эзэмшигч: Танайх муу ажиллаж байна. Хувьцааны ханш унаад байна. Та нар бид нарын хувьцааг өөр ашигтай компани руу оруулж өг. Талх чихэр, Мах импекс ч юм уу. Үгүй бол татан буулгах хэрэгтэй шүү дээ.

Хурлын дарга: Компанийн хувьд ашиг нэмэгдэж ажиллаж байна. Хувьцааг өөр хувьцаа руу шилжүүлж болдоггүй байгаа. Манайх нээлттэй хувьцаат компани учраас Хөрөнгийн зах зээл дээр та бүхэн харилцах брокерийн компаниараа дамжуулан хувьцаагаа арилжаад өөр компанийн хувьцаа худалдан авах эрх та бүхэнд нээлттэй байдаг шүү.

Хувьцаа эзэмшигч: Би жуулчидтай хамт очдог. 13-р зуун дээр өмсүүлдэг хувцас нь өмсүүлэхэд эвгүй. Тэрийгээ засаж сайжруулах хэрэгтэй байна.

Хувьцаа эзэмшигч: Би өмнө нь очсон хөшөөнөөс цааш их хог байсан тэрийг цэвэрлэх хэрэгтэй санагдсан.

Гүйцэтгэх захирал Энхсайхан: Үүнд тайлбар хэлэхэд одоо тийм зүйл байхгүй бүгдийг нь сайхан цэвэрлэхсэн байгаа шүү.

Хувьцаа эзэмшигч: Бид нар холоос ирсэн. Ядаж гарын бэлэг өгөх хэрэгтэй шүү дээ. Ашгийнхаа ядаж 20,30 саяд нь бид нарт юм өгч болно шүү дээ.

Хурлын дарга:

Санал хураалт: Хувьцаа эзэмшигчдэд саналын хуудасны заавартай танилцан саналын хуудас бөглүүлэхэд зөвлөж саналаа санал хураах хайрцагт хийхийг хэлэв.

Саналын хуудсаар

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.7923% буюу 46,696,480 ширхэг хувьцаатай 12 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99553% зөвшөөрсөн, 0.00428% татгалзсан, 0.00019% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
46,694,391	99.99553%	2,000	0.00428%	89	0.00019%

2. Компанийн 2018 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.7925% буюу 46,696,605 ширхэг хувьцаатай 12 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99572% зөвшөөрсөн, 0.00428% татгалзсан, 0.00000% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
46,694,605	99.99572%	2000	0.00428%	0	0.00000%

3. Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.7925% буюу 46,696,605 ширхэг хувьцаатай 12 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99572% зөвшөөрсөн, 0.00428% татгалзсан, 0.00000% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
46,694,605	99.99572%	2000	0.00428%	0	0.00000%

4. Компанийн нэрийг өөрчлөх тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 76.9224% буюу 35,994,838 ширхэг хувьцаатай 11 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99305% зөвшөөрсөн, 0.00556% татгалзсан, 0.00139% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
35,992,338	99.99305%	2,000	0.00556%	500	0.00139%

5. Хөрөнгө оруулалт санхүүжилтын төлөвлөгөөг хэлэлцэх тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 76.9224% буюу 35,994,838 ширхэг хувьцаатай 11 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99420% зөвшөөрсөн, 0.00556% татгалзсан, 0.00025 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
35,992,749	99.99420%	2000	0.00556%	89	0.00025%

6. Дүрмийн өөрчлөлтийг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 76.9224% буюу 35,994,838 ширхэг хувьцаатай 11 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99420% зөвшөөрсөн, 0.00556% татгалзсан, 0.00025 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
35,992,749	99.99420%	2,000	0.00556%	89	0.00025%

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

7. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 76.98% буюу 36,022,876 ширхэг хувьцаатай 15 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн санал:

8. Ердийн гишүүдэд:

	ТУЗ-ийн ердийн гишүүний нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Д.Даваасүрэн	32.51030%	70,266,866
2	Д.Даянбилгүүн	13.49458%	29,166,806
3	Б.Лхагвадорж	13.49460%	29,166,866
4	Б.Намуун	13.48595%	29,148,163
5	Х.Цэндбаяр	13.50570%	29,190,846
6	Ц.Энхтуяа	0.01496%	32,332
7	Ц.Энхсайхан	13.49391%	29,165,377

Хараат бус гишүүдэд:

	ТУЗ-ийн хараат бус гишүүний нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
7	Б.Алтансүвд	46.00487%	49,716,836
8	Б.Амарсанаа	27.00023%	29,178,777
9	Т.Одням	26.98921%	29,166,866
10	Л.Эрдэнэцэцэг	0.00569%	6,149

тус тус санал авч дараах гишүүд ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов.

Ердийн гишүүнд:

1. Д.Даваасүрэн
2. Д.Даянбилгүүн
3. Б.Лхагвадорж
4. Б.Намуун
5. Х.Цэндбаяр
6. Ц.Энхсайхан

Хараат бус гишүүнд:

7. Б.Алтансүвд
8. Б.Амарсанаа
9. Т.Одням

12 цагт 30 минутад тооллогын комиссын дарга С.Батцэрэн хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын тооллогын дүнг танилцуулснаар хурал өндөрлөв.

Хурлын дарга: **Д.Даянбилгүүн**

Тэмдэглэл хөтөлсөн: